



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/238

Булган

Хурдан морины уралдаан зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд 2019 онд зохион байгуулагдах аймгийн бүсийн хурдан морины уралдааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Хурдан морины уралдааныг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу уралдаанч хүүхэд, хурдан морины аюулгүй байдлыг ханган, хариуцлагатай зохион байгуулахыг “Булганхангай” морин спорт уяачдын холбоо /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.
3. Аймгийн Засаг даргын шийдвэрээр зохион байгуулагдаж буй аймгийн чанартай бүсийн хурдан морины уралдаанд нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газарт, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Т.Баярбат/-т тус тус даалгасугай.
4. Аймгийн бүсийн уралдаан зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190258

Аймгийн Засаг даргын
2019 оны 04 сарын 26-ны өдрийн ~~14~~15 тоот
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМАГТ 2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ХҮРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ХУВААРЬ

№	Уралдааны нэр	Хаана болох	Хугацаа	Зохион байгуулах эзэн	Хяналт тавих байгууллага	Тайлбар
1	"Булганхангай-Ирээдүйн түмэн эх 2019" аймгийн хаврын бүсийн уралдаан	Булган аймагт	2019.05.05	"Булганхангай" Морин спортын уяачдын холбоо	"Булганхангай" Морин спорт, уяачдын холбоо	5 нас
2	"Авзага хурд 2019" аймгийн урд бүсийн хаврын уралдаан	Гурванбулаг сум	2019.05.11	"Авзага хурд" Морин спорт, уяачдын холбоо	Булган аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Доод 3 нас Эрлийз 2 нас
3	"Агтын хийморь 2019" аймгийн хойд бүсийн уралдаан	Баян-Агт сум	2019.05.11	"Агтын хийморь" Морин спортын уяачдын холбоо		Доод 3 нас Эрлийз 2 нас
4	"Цонхлон хурд 2019" аймгийн хойд бүсийн уралдаан	Сэлэнгэ сум	2019.05.11	"Цонхлон хурд" Морин спортын уяачдын холбоо	Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газар	Доод 3 нас